



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 31,875,000.00 (гучин нэгэн сая найман зуун далан таван мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий, ашиглалтын хугацаа дууссан, Хьюндай Соната-7 маркийн, 87-95 УБА улсын дугаартай, (КМНЕВ41ВАВА298838 арлын дугаар) тээврийн хэрэгслийг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч Нийслэлийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Чинзориг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч В.Оюумаа, Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор тээврийн хэрэгслийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

